



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/105

Мандалговь

“Тааны амт” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сургалтын танхимын засвар (Онцгой байдлын газар)” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Тааны амт” ХХК-тай 19,400,000 (арван есөн сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Сургалтын танхимын засвар (Онцгой байдлын газар)” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тааны амт” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ю.Отгондэлгэр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060430